



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/384

Хэрлэн сум

Төсөл, арга хэмжээний
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 8.7, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 1 дүгээр сарын 19-ний “Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай” А/11 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад IV.1.16 дугаартай батлагдсан “Монголын нууц товчоо” цогцолборын барилгын интерьер, гадна тохижилт, гадна шугам сүлжээ (Хэнтий, Дэлгэрхаан сум)” төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсугай.

2. Төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах дүнг хавсралтаар баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

2023 оны 08 дугаар сарын 05 -ны
 4384 дугаар захирамжийн хавсралт
 Аймагийн Засаг даргын

Багцын дугаар	Багцын нэр	Төсөвт өртөг	2022 оны гэрээний дүн	2023 оны гэрээний дүн	2022 оны санхүүжилт	2023 оны санхүүжилт
Багц 1	"Монголын нууц товчоо" Цогцолборын интервьер, халгаалт салхивч, холбооны ажил (Хэнтий, Дэлгэрхаан сум)	569,431,422.0	566,510,833.0		113,886,000.0	455,545,422.0
Багц 2	"Монголын нууц товчоо" Цогцолборын бүтээц, гадна тохижилт, цахилгаан (Хэнтий, Дэлгэрхаан сум)	5,090,168,578.0	2,129,660,640	5,088,210,765.0	426,114,000.0	4,662,096,765.0